



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2024 оны 02 сарын 27 өдөр

Дугаар 09

Номгон

Төрийн захиргааны зарим албан хаагчдад  
зэрэг дэв олгох санал батлах тухай

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3.8.2, Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 02 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн захиргааны албан хаагчдад төрийн алба хаасан болон тухайн албан тушаалд ажилласан хугацаа, төрийн албан хаагчийн үйл ажиллагаа, мэргэшлийн түвшингийн үнэлгээг үндэслэн зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгох саналыг хавсралтаар баталсугай.

2.Төрийн захиргааны албан хаагчдад шинээр болон ахиулан олгох зэрэг дэвийн саналыг УИХ-ын 2019 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-ын дагуу аймгийн Засаг даргад уламжлан шийдвэрлүүлэхийг Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргын үүргийн түр орлон гүйцэтгэгч (Д.Сарангарав)-д даалгасугай.

3.Цаашид төрийн захиргааны албан хаагчидын зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгуулах саналаа ирүүлэхдээ УИХ-ын 2019 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-д заасан болзол, шаардлагыг хангасан талаарх нотлох баримтыг бүрэн бүрдүүлэн ирүүлж байхыг байгууллагын дарга нарт зөвлөсүгэй.

ДАРГА



Д.ЭНХЖАРГАЛ

• 642213135